

**Glenview хотын сургуулийн 34-р Дүүрэг**

**Дүүргийн iPad-ийг хувь хүн нэг бүр эзэмших сургалтын санаачлага  
Сурагч/ эцэг эхийн гарын авлага  
Бодлого, журам ба мэдээлэл**

**2011 оны 9 сар**

**2013 оны 6-р сард нэмэлт өөрчлөлт оруулсан**

**2014 оны 7-р сард нэмэлт өөрчлөлт оруулсан**

**2015 оны 7-р сард нэмэлт өөрчлөлт оруулсан**

**2017 оны 4-р сард нэмэлт өөрчлөлт оруулсан**

**2018 оны 1-р сард нэмэлт өөрчлөлт оруулсан**

**2019 оны 1-р сард нэмэлт өөрчлөлт оруулсан**

**2019 оны 10-р сард нэмэлт өөрчлөлт оруулсан**

## Оршил

Бидний хүн нэг бүр эзэмших сургалтын санаачлага бол 21-р зууны суралцагчдад техник хэрэгсэл болон холбогдох эх үүсвэрээр хангах явдал юм. Боловсролын хувьд чадварлаг байх гэдэг нь боловсролын хөтөлбөрийг бүхэлд нь технологийн хувьд ямарч асуудалгүйгээр цогц байлгахыг шаарддаг байна. Судалгааны болон сургуулийн тайлангаас харахад хувь хүн нэг бүр эзэмших тооцоолох төхөөрөмжийг ашигладаг сурагчид боловсролын орчинд илүү зохион байгуулалттай байж, идэвхитэй суралцаж, сургуульдаа тогтмол явж, технологийн талаар илүү мэдлэг, ойлголттой, мэдээлэл санаачлагыг бүтээгч болон загвар зохион бүтээгч нар болдог байна. Технологийн хүртээмжийг нэмэгдүүлэх нь ирээдүйд нэн чухал бөгөөд 21-р зууны сурагчдын сурах нэг хэрэгсэлд Apple iPad байгаа юм. iPad-ийн хувь хүн бүрт хувьчлан эзэмшүүлэх хэрэглээ нь сурагчдыг өөрсдийн бүрэн нөөц бололцоогоо нэмэгдүүлэх, цаашдын сургалтанд бэлтгэх боломжийг олгож идэвхижүүлэх нэг арга юм. Apple iPad нь суралцах үйл явцыг илүү сонирхолтой, хүртээмжтэй болгодог төхөөрөмж юм. Суралцах үйл явц нь сурагчид, сурган хүмүүжүүлэгчид, эцэг эх болон орон нутгийн боловсролын бусад бүлгүүдийн хоорондын тасралтгүй харилцан үйлчлэлээс хамаардаг. Технологийн нэвтрэлт нь багшийн амин чухал үүргийг бууруулдаггүй. iPad-ийг үр дүнтэй зааж, ашиглаж суралцах нь технологийг сургалтын хөтөлбөрт хэзээ ч, хаана ч нэгтгэж болох юм.

### 1.0 Ерөнхий мэдээлэл

Энэхүү баримт бичигт тусгагдсан Бодлого, журам, мэдээлэл нь Дүүргийн бүх iPad-ууд (цаашид "Дүүргийн iPad-ууд" гэх) болон Glenview хотын сургуулийн 34-р Дүүргийн сурагчдын ашигладаг хэрэгслүүдэд хамаарна.

Нэмж дурдахад дүүргийн iPad-г ашигласнаар сурагч Удирдах Зөвлөлийн бүх бодлого, дүрмийг дагаж мөрдөхийг хүлээн зөвшөөрч байгаа ба үүгээр хязгаарлагдахгүй:

**Бодлого 6:235-Цахим Сүлжээнд нэвтрэх:** Дүүргийн цахим Сүлжээ түүний дотор Дүүргийн эзэмшлийн компьютер, хөдөлгөөнт төхөөрөмж, интернет, Дүүргийн орон нутгийн болон/өргөн сүлжээ ("Сүлжээ")-гээр мэдээллийн эх үүсвэрээ хуваалцах, шинэ санаачлага, харилцаа холбоог сайжруулах замаар боловсролын түвшинг дэмжих нь Дүүргийн боловсролын хөтөлбөрийн зааврын нэг хэсэг юм. Захирагч болон түүний томилсон ажилтан энэхүү Бодлогын дүрэм, журмыг боловсруулж, техникийн систем хариуцсан ажилтныг томилоно. Дүүрэг Сүлжээг ашиглах үед алдагдсан, эвдэрсэн, ашиглах боломжгүй мэдээлэл, эсвэл интернетээс олж авсан, дамжуулсан мэдээлэлд хариуцлага хүлээхгүй. Цаашилбал, Сүлжээнд нэвтэрснээс үүдэлтэй зөвшөөрөлгүй төлбөр, хураамжийг Дүүрэг хариуцахгүй. **Бодлогыг бүхлээр нь үзэхийн тулд дүүргийн вэбсайтруу орж-зөвлөл -дүүргийн бодлогыг үзнэ үү.**

**Бодлого 7: 180-ын Дээрэлхэх, Дарамтлах:** Дээрэлхэх, айлган сүрдүүлэх, дарамтлах нь сурагчдын суралцах болон сургуулийн боловсрол олгох чадварыг бууруулдаг. Сурагчдыг эдгээр саад учруулах зан байдлын оролцооноос урьдчилан сэргийлэх нь Дүүргийн чухал зорилт юм. **Бодлогыг бүхлээр нь үзэхийн тулд дүүргийн вэбсайтруу орж-зөвлөл -дүүргийн бодлогыг үзнэ үү.**

**Бодлого 7: 190-Сурагчдын зан төлөв:** Сургуулийн захиргаа нь сурагчдыг дуулгаваргүй, ёс зүйгүй үйлдэл гаргасан тохиолдолд сахилгажуулах эрхтэй. Боловсролын Удирдах Зөвлөлийн бодлогод тусгасны дагуу дуулгаваргүй байдал, зүй бус үйлдэл гаргах гэдэг нь төрөлх чанар, учир шалтгааны хувьд зүй бус, зориудаар хохирол учруулах эсвэл сургуулийн удирдлагууд сургуулийн үйл ажиллагаатай холбоотой болон сурагч, сургуулийн ажилчдын эрх, эсвэл үүнтэй адил эрсдэл учруулах ихээхэн хэмжээний гэмтэл, саад учруулахыг урьдчилан таамаглахыг хэлнэ. **Бодлогыг бүхлээр нь үзэхийн тулд дүүргийн вэбсайтруу орж-зөвлөл -дүүргийн бодлогыг**

## **ҮЗНЭ ҮҮ.**

### **1.1 Дүүргийн iPad-г хүлээн авах**

Дүүргийн iPad-уудыг сургуулийн хичээл эхлэхээс өмнө эсвэл сургуультай танилцах үеэр iPad-уудыг хуваарилах болно. Эцэг эх, сурагчид энэ гарын авлагын хамгийн арын хуудсанд байгаа Цахим Сүлжээнд нэвтрэх Сурагч, Эцэг Эхийн Зөвшөөрөл, мөн Дүүргийн iPad-ыг хэрэглэх Сурагч, Эцэг Эхийн үүрэг зэрэг баримтууд дээр Дүүргийн iPad тараахаас өмнө гарын үсэг зурж, буцаан өгсөн байх ёстой. Эцэг эхүүд дүүргийн вэб хэрэгсэл / апп, Google болон онлайн данс түүний хяналтын тухай мэдээллийг заавал уншиж, уншсанаа баталгаажуулах ёстой.

### **1.2 Дүүргийн iPad-г буцааж өгөх**

Дүүргийн iPad болон түүний дагалдах хэрэгслийг хичээлийн жил бүрийн сүүлийн долоо хоногт тухайн сурагчын ангийн багш/ Технологийн багшийн оролцоотойгоор Glenview 34-р Дүүргийн сургууль руу буцаан өгнө. Хэрэв сурагч хичээлийн жилийн дундуур Glenview 34-р Дүүргийн сургуулиас шилжих тохиолдолд Дүүргийн iPad-г тухайн үед сургуулийн оффис руу буцааж өгнө. Бусад шалтгаанаар Glenview 34-р Дүүргийн сургуулийн бүртгэлээс хасагдсан, хөөгдсөн, эсвэл элсэлтээ цуцалж байгаа сурагчид Дүүргийн iPad болон дагалдах хэрэгслүүдийг тухайн өдөр сургуулийн оффис руу буцааж өгөх ёстой.

### **1.3 Эвдрэх, Алдагдах, Буцааж өгөөгүй тохиолдолд хүлээх хариуцлага**

Удирдах Зөвлөлийн бодлого 7: 170, тогтоосны дагуу Эвдэн сүйтгэх гэдэгт "Сургуулийн өмч хөрөнгийг эвдэн сүйтгэх, түүнтэй адил хохирол учруулсан тохиолдолд Зөвлөл нь сурагчид болон тэдний эцэг эх / асран хамгаалагчийн зүгээс нөхөн сэргээхийг эрэлхийлэх болно" гэж мэдэгджээ.

Сурагч хичээлийн жилийн төгсгөлд болон 34-р Дүүргийн сургуулиас шилжин явсан үед Дүүргийн iPad-ийг буцааж өгөөгүй тохиолдолд уг төхөөрөмжийн хариуцлагыг тооцож, эрүүгийн болон иргэний хариуцлага хүлээлгэх болно. Сурагч Дүүргийн iPad-ийг орлуулах зардлыг төлнө. Дүүргийн iPad-г буцааж өгөхгүй бол хулгайн гэмт хэргийн тайланг Glenview Цагдаагийн газарт гаргаж өгөх болно. Түүнчлэн сурагч Дүүргийн iPad-ийн эвдрэл, алдагдлыг өөрийн багш, технологийн багшид шууд мэдэгдэх үүрэгтэй ба хичээлийн жилийн турш санамсаргүй гэмтэл, эвдрэл, засварын анхны тохиолдол гарсан бол сурагчид төлбөр ноогдуулахгүй. Дараачийн бүх гэнэтийн хохирлын төлбөрийг тооцно. Дүүргийн тодорхойлсоны дагуу зориудаар гэж үзсэн бүх хохирол, төхөөрөмжийг солих, засах ажлыг сурагч өөрөө хариуцах болно. Гадна талын хавтас, цэнэглэгч, кабель гэх мэт эвдэрсэн, алдагдсан эсвэл хулгайлагдсан хэрэгслүүдэд сурагч/ эцэг эх / асран хамгаалагч үүрэг хүлээнэ. Хэрэв дагалдах хэрэгсэл эвдэрсэн, алдагдсан эсвэл хулгайд алдсан бол Дүүрэг төлбөрийг чөлөөлөөгүй тохиолдолд Эцэг эх / асран хамгаалагч тухайн Дүүргийн өгсөн дагалдах хэрэгслийг бүрэн солих зардлыг өөрөө хариуцна. Сургуулийн байрнаас гадуур алдагдсан тохиолдолд орлуулах төхөөрөмж хүсэхийн өмнө эцэг эх / асран хамгаалагч цагдаагийн байгууллагад өргөдөл гаргах шаардлагатай.

## 2.0 Дүүргийн iPad-ын арчилгаа

Сурагчид Дүүргийн зүгээс олгосон iPad-ийн ерөнхий арчилгааг хариуцна. Эвдэрсэн, зохих ёсоор ажиллахаа больсон Дүүргийн iPad-ийн тоног төхөөрөмжийн үнэлгээг Сургалтын эх үүсвэрийн төвөөр дамжуулан Технологийн хэлтэст аль болох хурдан хүргэх шаардлагатай.

### 2.1 Ерөнхий анхаарулга

- Дэлгэцийг цэвэрлэхийн тулд зөвхөн цэвэр, зөөлөн даавуу хэрэглэх; ямар ч төрлийн цэвэрлэгч бодис хэрэглэхгүй байх.
- Эвдрэлээс сэргийлэхийн тулд Дүүргийн iPad-ийн залгуур, кабелийг болгоомжтой ашиглах.
- Дүүргийн iPad дээр нь Glenview 34-р дүүргийн өмч бус бичиглэл, зураг, наалт, шошгогүй байх ёстой.
- Дүүргийн iPad-уудыг хэзээ ч шидэх, хаяж, гишгэж болохгүй.
- Дүүргийн iPad-уудыг хэзээ ч түгжээгүй шүүгээ, түгжээгүй машин, хараа хяналтгүй газар үлдээх ёсгүй.
- Дүүргийн iPad-ийг хэт температур, чийгшил, агааржуулалт багатай газарт удаан хугацаагаар бүү орхи.
- Дүүргийн iPad-аас хоол хүнс, уух зүйлсийг хол байлга.
- Сурагчид 34-р Дүүргийн ажилтнаас удирдамж аваагүй тохиолдолд төхөөрөмжийг өөр сурагчид зээлдүүлэхгүй.
- Сурагчид автобусаар зорчихдоо iPad-аа үүргэвчиндээ байнга байлгах үүрэгтэй.
- Сурагчид Дүүргийн iPad-ийг сургууль орж байгаа өдөр бүр цэнэглэж байх үүрэгтэй.
- Дүүрэг ашиглагдах ёстой Дүүргийн iPad бүрт хамгаалалтын хавтасыг олгоно.

### 2.2 Дүүргийн iPad-уудыг зөөх, хадгалах, автобусаар авч явах, хамгаалах

Дүүргийн iPad-ын хамгаалалтын хавтас нь iPad-ийг хамгаалах хангалттай хэмжээний зөөлөвтэй бөгөөд сургууль дотор төхөөрөмжийг авч явахад тохиромжтой байдлаар хангагдсан болно. Дараах удирдамжийг дагаж мөрдөнө:

- Дүүргийн iPad-ийг үргэлж хамгаалалтын хавтаст байлгах. Дүүргийн iPad-ын дэлгэц дээр үүргэвчний тасалгаануудын хэт их дарамт, жинг байрлуулахаас зайлсхийхийн тулд бусад хэрэгсэл (хавтас, сурах бичиг гэх мэт) хадгалдаг тасалгаанаас тусад нь байрлуулах.
- Дүүргийн iPad-уудыг усны сав, бусад шингэн зүйл хадгалдаг байрлалд зөөх, хадгалах, ашиглах ёсгүй.
- Сурагчид Дүүргийн iPad-г ашиглаагүй тохиолдолд iPad-ыг аюулгүй газар хадгална. Дүүргийн iPad-ыг цүнх, ширээ эсвэл бусад байршилд хадгалж байх явцад дээр нь юу ч тавьж болохгүй.
- Сурагчид Дүүргийн iPad-ийг гэрээр авах эрхтэй болсоны дараа орой бүр эдгээрийг хийхийг зөвлөж байна.
- Дүүргээс хангасан тээврийн хэрэгслээр зорчих эсвэл хүлээж байх явцдаа iPad-ууд хаалттай, сурагчдын үүргэвчинд байх ёстой.
- Сургуулийн дараа болон сургуулийн газар нутаг дээр анги дотор бус тохиолдолд Дүүргийн бус тээврийн хэрэгсэл хүлээж байх явцад бүх iPad-ууд сурагчдын үүргэвчинд хамгаалагдсан байна.
- Дүүргийн iPad-ыг сургууль, гэртээ байх явцад эцэг эхийн автомашинд хадгалах ёсгүй. Сурагч Дүүргийн iPad-ийг хадгалах найдвартай газар шаардлагатай байгаа бол сурагч багшаас хадгалах газар асууж болно.

- Дүүргийн iPad-дыг ямар ч нөхцөлд хараа хяналтгүй газар үлдээх ёсгүй. Хяналтгүй газарт сургуулийн талбай, сургуулийн хотхон, цайны газар, номын сан, түгжээгүй анги, хувцас солих өрөө, үүдний танхим, бусад хяналтгүй газрууд багтдаг. Эдгээр газарт үлдсээсэн дүүргийн iPad хулгайд алдагдах аюултай. Хэрэв дүүргийн iPad-ийг хараа хяналтгүй газраас олвол Сургалтын эх үүсвэрийн төв эсвэл Захирлын өрөөнд аваачиж өгнө. Сурагч Дүүргийн iPad-г буцаан олж авахын тулд Захирал/Технологийн багштай уулзана.

### **2.3 Дэлгэцийн арчилгаа**

Дүүргийн iPad-ийн дэлгэцийг ширүүн байдлаар ашиглавал эвдэрч болзошгүй. Дэлгэц дээр хэт их даралт үүсгэснээс болж гэмтэх магадлалтай эмзэг байдаг.

- Дүүргийн iPad-ийн дээд тал болон дэлгэц дээр бүү дар
- Дүүргийн iPad-ийн ойролцоо дэлгэцэнд дарамт учруулж болох зүйлийг бүү байрлуул.
- Гэр болон хавтасад даралт, шахалт өгөх юу ч битгий байрлуул.
- Дэлгэцийг зөөлөн, хуурай даавуу эсвэл цахилгаанждаггүй даавуугаар цэвэрлээрэй.
- Дүүргийн iPad-ийг шүүгээ, хана, машины хаалга, шал гэх мэт зүйлд цохиж болохгүй ба энэ нь дэлгэцийг эвдэх магадлалтай болно.

### **2.4 Дүүргийн iPad -ийн таних тэмдэг**

Дүүргийн iPad-ийг дүүргийн хэмжээнд тогтоосон журам, сургуулийн захирал тус бүр тэмдэглэгээгээ хийнэ. Дүүргийн iPad-уудыг дараахь байдлаар таньж болно:

- Бичигдсэн сери, дугаар
- Glenview сургуулийн 34-р Дүүргийн өмчийн наалт
- Сурагчийн нэр/ овог/ сериал дугаар, сургуулийн ажилтны наасан Вэб дугаар

### **3.0 Дүүргийн iPad-ийг сургууль дээрээ ашиглах**

Дүүргийн iPad-ийг өдөр бүр сургуульдээр ашиглах зориулалттай. Дүүргийн iPad-ийг багш нарын зааварчилгаанаас гадна сурагчийн ангиас хамааран сургуулийн талаарх мессеж, зарлал, хуанли, хуваарийг ашиглах боломжтой. Сурагчид Дүүргийн iPad-ийг хэрэв багш авчиргахыг хориглосон зааварчилгаа өгөөгүй бол ангидаа авчиргах үүрэгтэй.

#### **3.1 Дүүргийн iPad-ийг гэртээ үлдээх**

Дүүргийн iPad-ыг гэртээ удаа дараалан орхисон сурагчид iPad хэрэглэх эрхээ хоёр долоо хоногийн хугацаанд алдах бөгөөд Дүүргийн iPad-ыг багшдаа өгч сургуульдээр үлдээнэ.

#### **3.2 Дүүргийн iPad-ын засварын ажил**

Дүүргийн iPad-д Сургалтын нөөцийн төвөөр дамжуулан Технологийн хэлтэст засвар хийхээр үлдээхэд зээлийн iPad-ийг сурагчдад олгож болно. Нөөц бололцооноос хамаараад Дүүргийн iPad зээлдэхэд түр саатах магадлал байж болно.

#### **3.3 Дүүргийн iPad-ийг цэнэглэх**

Дүүргийн iPad-ыг өдөр бүр сургууль дээрээ бүрэн цэнэглэж авчрах ёстой. Сурагчид орой бүр Дүүргийн iPad-аа цэнэглэх үүрэгтэй. Энэхүү бодлогыг удаа дараа зөрчсөн (дор хаяж гурван өдөр, дараалсан өдрөөр бус) тохиолдолд Сурагч iPad-аа гэртээ хэрэглэх эрхээ 2

долоо хоногоор алдахад хүргэж, Дүүргийн iPad-ыг багшдаа өгч сургуульдээр үлдээнэ.

### **3.4 Зураг/Нууц үг/Дэлгэцийн зураг / Арын дэвсгэр зураг**

Зохисгүй медиа үүсгэх, авах, үзэх, и-мэйл илгээх, төхөөрөмжид татаж авахгүй. Зохисгүй медиаг дэлгэцийн зураг эсвэл арын дэвсгэр зураг болгон ашиглахгүй. Зохисгүй медиа дотор зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй буу, зэвсэг, садар самуун материал/зохисгүй ил тодоор үзүүлэх, хүчирхийлэл, бүдүүлэг үг хэллэг, доромжлол, айлган сүрдүүлэлт, согтууруулах ундаа, мансууруулах бодис, танхай бүлэглэлтэй холбоотой тэмдэг, зургийг агуулсан зэрэг багтана. Зохисгүй медиа илгээх, татаж авах эсвэл хуваалцсан сурагчдыг Удирдах Зөвлөлийн Бодлого, журам, Дүүргийн ёс зүйн дүрмийн дагуу сахилгажуулна. Хэрэв сурагч зохисгүй зураг эсвэл мэдээллийг имэйлээр хүлээж авбал насанд хүрэгчдэд (багш, ажилтан, эцэг эх) мэдэгдэх нь сурагчийн үүрэг юм. Дүүргийн iPad-д нэвтрэхийн тулд нууц код үүсгэхгүй.

### **3.5 Дуу, хөгжим, тоглоом, эсвэл програм**

Багш сургалтын зорилгоор зөвшөөрөл өгснөөс бусад тохиолдолд дууг байнга хаасан байна. Ангийн багш дүүргийн iPad-дээр хөгжим нэмж оруулах боломжтой. Дүүргийн Өөртөө Үйлчлэх систем, ангийн багшийн зааснаас бусад тохиолдолд сурагчийн төхөөрөмж дээр Интернет тоглоом (сайт) эсвэл програмыг ашиглах, суулгахыг зөвшөөрөхгүй. Хэрэв тоглоомын програм суулгах шаардлагатай бол Glenview 34-р дүүргийн ажилтны санал бодол, удирдамжийн дагуу байх болно. Дүүргийн програм хангамж/ програмыг дүүргийн iPad дээр суулгаж байнга нэвтрэх боломжтой байлгаж, Өөртөө Үйлчлэх системээр дамжуулан байнгын ашиглах боломжтой байх ёстой. Дүүргийн iPad-ын апп дээр мэдээллийг хадгалах ба Glenview 34-р Дүүргийн Google-ийн бүртгэлийн боловсролын дансанд хадгалагдана.

Онлайн хөгжим одоогоор Glenview 34-р Дүүргийн сурагчдын хувьд ашиглагдаж эхлээгүй байгаа. Сурагчдад онлайн хөгжмийн систем ашиглахгүй байхыг зааварлаж байгаа бөгөөд зөрчил гаргасан тохиолдолд сахилгын арга хэмжээ авна. Apple-ийн хязгаарлалтыг үндэслэн Glenview 34-р Дүүрэг нь Apple болон манай шүүлтүүрийн систем хоёуланд боломжтой зүйлийг харгалзан төхөөрөмж бүрт хөгжим өгөхийг зөвшөөрөх эсвэл үгүйсгэх эрхийг эдэлдэг. Glenview 34-р Дүүрэг бүх сурагчдын төхөөрөмж дээрх хөгжмийн програмуудыг удирдахын тулд Apple-тэй үргэлжлүүлэн ажиллаж байна. Ямар ч хөгжим (Apple радио станцууд, онлайн хөгжим гэх мэт) ашиглахыг хүсэхгүй байгаа хүмүүсийн хувьд [bengle@glenview34.org](mailto:bengle@glenview34.org) (Сургалтын технологийн гүйцэтгэх захирал) руу холбоо бариарай. Тэрээр сурагчдын төхөөрөмж дээр хязгаарлалт хийхэд тантай хувьчлан ажиллах болно.

### **3.6 Хэвлэх**

Дүүргийн iPad-аас сургууль дээр хэвлэх боломжгүй юм.

### **3.7 Гэрийн интернэт холболт**

Дүүргийн iPad-г Дүүргээс гадуур ашиглахад сурагчид сургууль дээрээ байхдаа мөрддөг Бодлого, дүрэм, журам, удирдамжийг ижил дагаж мөрднө. Сурагчид iPad-ыг гэр бүлийн гишүүд эсвэл бусад хүмүүс гэрт ашиглахад хяналт тавих үүрэгтэй. Сурагчид Дүүргийнхээ iPad дээр үнэгүй утасгүй сүлжээнд холбогдох боломжтой. Гэртээ байхдаа сурагчдын интернетийн үйл ажиллагааг эцэг эх хянах, удирдах үүргийг хариуцна. Гэрийн нөхцөлд хүүхдийнхээ iPad-ийн хэрэглээ, Интернетэд нэвтрэхийг хязгаарлах нь эцэг эхийн үүрэг юм. Дүүргийн iPad-ууд сургуульд ашигладаг ижил тохиргоотой гэрт мөн шүүгддэг. 2019 - 2020

оны хичээлийн жилд Дүүрэг Аюулгүй шүүлтүүрийн шийдлийг ашиглаж эхлэнэ. Гэртээ байхдаа зохисгүй материалруу нэвтрэхийг завдсан сурагчид сургуулийн өдрүүдэд зөрчил гаргасан шийтгэлтэй адил сахилгын шийтгэл хүлээнэ.

#### **4.0 Өөрийн файлаа хянах, ажлаа хадгалах.**

##### **4.1 Apple -ийн тодорхойлолт**

Дүүрэг нь сурагчдын төхөөрөмжийг удирдахад туслах Apple-ын тодорхойлолтыг (ID-г) ашигладаггүй.

##### **4.2 Дүүргийн iPad хадгалах / 34- Дүүргийн Сүлжээний нөөцөд хадгалах**

Сурагчид хийсэн ажлаа Дүүргийн iPad дээр шууд хадгалах боломжтой. Мөн сурагчдаас хийсэн бичиг баримтаа SD34 Google Docs-ийн сургалтын дансны бүртгэлд хадгалахыг зөвлөж байна. Нэмж хэлэхэд, сурагчид баримтуудаа өөрлүүгээ, эцэг эхрүүгээ (жилийн өдрүүдээс хамаарна) мөн багшруугаа илгээх боломжтой. Анхаарлаа хандуулна уу: Дүүргийн iPad-ын хадгалах багтаамжыг ашиглах боломжтой боловч энэ нь ХЯЗГААРЛАГДМАЛ бөгөөд дахин дүрслэх, төхөөрөмжийн алдаа гарсан тохиолдолд буцааж СЭРГЭЭГДЭХГҮЙ. Механик гэмтэл эсвэл санамсаргүй устгалаас шалтгаалж хийсэн ажлаа устгахгүй байх нь сурагчийн үүрэг. Хэрэв iPad-ийн алдаа гарвал сурагч нөхцөл байдлыг тайлбарлахын тулд багшруу дуудлага хийх, имэйл илгээх, биечлэн ярилцах зэргээр хийнэ. Нөхцөл байдал бүрд хувь хэрэг тус бүрийг үндэслэн шийднэ.

##### **4.3 Сүлжээний холболт**

Glenview сургуулийн 34-р Дүүргийн сүлжээ найдвэртэй ажиллана гэдэгт 100% баталгаа өгөхгүй. Хэрэв Сүлжээ тасарсан ховор тохиолдолд Дүүрэг алдагдсан, алга болсон мэдээлэлд хариуцлага хүлээхгүй болно.

#### **5.0 Дүүргийн iPad-ийн онлайн нөөц / програм хангамж**

##### **5.1 COPPA (Хүүхдийн онлайн нууцлал хамгааллын тухай хууль)**

Бидэнд болон бидний сурагчдын онлайн сургалтын хэрэгслүүдийн давуу талыг ашиглах бодит зүйлийн нэгд Хүүхдийн онлайн нууцлалын хамгааллын тухай хууль (COPPA) юм. Энэ хууль нь вэбсайтууд болон онлайн үйлчилгээнүүдэд (гар утасны програмуудыг багтаана) хамааралтай бөгөөд 13-аас доош насны хүүхдүүдийн хувийн мэдээллийг цуглуулах, ашиглах үйл ажиллагааг зохицуулдаг. Бид гуравдагч этгээдийн сайттай ажиллахдаа хуулийн хүрээнд ажиллах ёстой.

Ихэнх тохиолдолд онлайн үйлчилгээ нь хуулийн дагуу 13-аас доош насны сурагчдын өмнөөс данс үүсгэж, удирдах боломжийг сургуулийн Дүүргүүдэд олгодог; гэсэн хэдий ч олон компаниуд үүний дагуу ажилладаггүй. Холбооны Худалдааны Коммисын (FTC) зөвлөж байгаагаар ялангуяа хүүхэдүүд чиглэсэн бүх вэбсайтууд болон онлайн үйлчилгээнүүд, нууцлалын бодлогыг онлайнгаар байрлуулах, ингэснээр зочид операторын мэдээллийн талаар хялбархан мэдээлэл олж авах боломжтой юм.

Glenview сургуулийн 34-р Дүүрэг гуравдагч этгээдийн хариуцдаг боловсролын вэб дээр суурилсан хэд хэдэн програмыг ашигладаг ба үүнд үүгээр хязгаарлагдахгүй Google Apps (GSuite), Schoology, IXL Math, Seesaw гэх мэт ижил төрлийн үйлчилгээнүүд орно. Хүүхдийн онлайн нууцлал хамгааллын тухай хууль COPPA-ийн дагуу эдгээр вэбсайтууд 13-аас доош насны хүүхдээс хувийн мэдээлэл авахаас өмнө эцэг эхээс болон эцэг эхийн өмнөөс зөвшөөрөл

авсан сургуулийн дүүргээс зөвшөөрлийг авах ёстой.

Glenview 34-р Дүүрэг COPPA шаардлагыг дагаж мөрддөг, зөвхөн боловсролын зорилгоор ашигладаг вэбсайт операторуудтай гэрээ байгуулдаг. Glenview 34-р Дүүрэг таны хүүхдийн хувийн нууцлалыг хүндэтгэдэг ба ашигладаг вэбд суурилсан хэрэгсэл, програмууд дээр үндэслэн хувийн мэдээллүүд зөвхөн эдгээр програмд хуримтлагдаж ашиглагддаг гэдгийг эцэг эхэд мэдүүлэхийг хичээж байна. Эдгээр бүх Апп-д хандахыг хүсвэл (ангийн түвшингээр) App програмын жагсаалт 1:1 Эцэг эхийн хувилбар -- 19 -20 руу орно уу. Дүүрэг бүх эцэг эхчүүдэд хичээлийн жилийн турш ашиглагдаж байгаа сайтуудын онлайн жагсаалтыг гаргаж өгөх болно. Жилийн турш сайтууд, програмууд нэмэгдэх боломжтой тул шинэчлэгдсэн имэйлийг ашиглаарай. Хэрэв танд ямар нэг асуулт байвал сургуулийн захирал, Технологийн Ажилтан эсвэл Brian Engle (Сургалтын албаны Гүйцэтгэх Захирал)-тай холбоо барина уу.

Апп/Web хуудас	Нүүр хуудас	COPPA хуулийн холбоос
Artsonia	<a href="http://www.artsonia.com/">http://www.artsonia.com/</a>	<a href="http://www.artsonia.com/privacy.asp">http://www.artsonia.com/privacy.asp</a>
Google Suite	<a href="https://www.glenview34.org/parents/forms">https://www.glenview34.org/parents/forms</a>	<a href="https://play.google.com/about/families/coppa-compliance/">https://play.google.com/about/families/coppa-compliance/</a>
AUP	<a href="https://www.glenview34.org/parents/forms">https://www.glenview34.org/parents/forms</a>	NA
Cell Phone	<a href="https://www.glenview34.org/parents/forms">https://www.glenview34.org/parents/forms</a>	NA
Schoology	<a href="https://www.schoology.com/about">https://www.schoology.com/about</a>	<a href="https://www.schoology.com/privacy">https://www.schoology.com/privacy</a>
Seesaw	<a href="http://web.seesaw.me/">http://web.seesaw.me/</a>	<a href="http://web.seesaw.me/privacy-policy">http://web.seesaw.me/privacy-policy</a>
Mackin Via	<a href="https://www.mackinvia.com/">https://www.mackinvia.com/</a>	<a href="https://www.mackinvia.com/Privacy">https://www.mackinvia.com/Privacy</a>
Connect-Ed	<a href="https://connected.mcgraw-hill.com/connected/login.do">https://connected.mcgraw-hill.com/connected/login.do</a>	<a href="http://www.mheducation.com/privacy.html?scrlly_brkr">http://www.mheducation.com/privacy.html?scrlly_brkr</a>
Axis 360	<a href="http://axis360.site.baker-taylor.com/">http://axis360.site.baker-taylor.com/</a>	NA
IXL	<a href="https://www.ixl.com/">https://www.ixl.com/</a>	<a href="https://www.ixl.com/privacypolicy">https://www.ixl.com/privacypolicy</a>
Quizziz	<a href="https://quizizz.com">https://quizizz.com</a>	<a href="https://quizizz.com/tos">https://quizizz.com/tos</a>
CK-12 Free Online Books, Flashcards, StudyGuides	<a href="http://www.ck12.org/student/?_ga=1.5645178.878801588.1490280572">http://www.ck12.org/student/?_ga=1.5645178.878801588.1490280572</a>	<a href="http://www.ck12.org/student/?_ga=1.5645178.878801588.1490280572">http://www.ck12.org/student/?_ga=1.5645178.878801588.1490280572</a>
Kids A-Z	<a href="https://www.kidsa-z.com/main/Login">https://www.kidsa-z.com/main/Login</a>	<a href="http://help.learninga-z.com/customer/portal/articles/1649236-privacy">http://help.learninga-z.com/customer/portal/articles/1649236-privacy</a>
AIMSWeb Plus	<a href="https://app.aimswebplus.com/#/login">https://app.aimswebplus.com/#/login</a>	<a href="https://www.pearson.com/us/privacy-statement.html">https://www.pearson.com/us/privacy-statement.html</a>
Access Testing/Online EL Screener	<a href="https://www.isbe.net/Pages/EL2018-2019AccessforELL.aspx">https://www.isbe.net/Pages/EL2018-2019AccessforELL.aspx</a>	<a href="https://www.isbe.net/Pages/Privacy-Policy.aspx">https://www.isbe.net/Pages/Privacy-Policy.aspx</a>



Apple School Manager	<a href="https://school.apple.com/">https://school.apple.com/</a>	<a href="https://www.apple.com/privacy/">https://www.apple.com/privacy/</a>
COGat	<a href="http://www.cogat.org/site/login">http://www.cogat.org/site/login</a>	<a href="https://cms.riversideinsights.com//uploads/c3e4cb4f909844ff8a55ffd4c0072ecc.pdf">https://cms.riversideinsights.com//uploads/c3e4cb4f909844ff8a55ffd4c0072ecc.pdf</a>
Digits/Realize/EEasybridge - Middle school math	<a href="https://www.pearsonschool.com/index.cfm?locator=PSZwZ5">https://www.pearsonschool.com/index.cfm?locator=PSZwZ5</a>	<a href="https://www.pearsonschool.com/index.cfm?locator=PSZ19q">https://www.pearsonschool.com/index.cfm?locator=PSZ19q</a>
EmbraceMTS S	<a href="https://www.embraceeducation.com/">https://www.embraceeducation.com/</a>	<a href="https://www.embraceeducation.com/privacy-policy/">https://www.embraceeducation.com/privacy-policy/</a>
EmbraceIEP	<a href="https://www.embraceeducation.com/">https://www.embraceeducation.com/</a>	<a href="https://www.embraceeducation.com/privacy-policy/">https://www.embraceeducation.com/privacy-policy/</a>
IAR (State Testing)	<a href="https://www.isbe.net/iar">https://www.isbe.net/iar</a>	<a href="https://www.isbe.net/Pages/Privacy-Policy.aspx">https://www.isbe.net/Pages/Privacy-Policy.aspx</a>
IWAS/SIS/iSTAR	<a href="https://www.isbe.net/Pages/istar.aspx">https://www.isbe.net/Pages/istar.aspx</a>	<a href="https://www.isbe.net/Pages/Privacy-Policy.aspx">https://www.isbe.net/Pages/Privacy-Policy.aspx</a>
VersaTrans (Bus System)	<a href="https://www.tylertech.com/products/versatrans">https://www.tylertech.com/products/versatrans</a>	<a href="https://www.tylertech.com/privacy">https://www.tylertech.com/privacy</a>
EC/Kindergarten Screening	<a href="https://www.pearson.com/us/prek-12.html">https://www.pearson.com/us/prek-12.html</a>	<a href="https://www.pearson.com/us/privacy-statement.html">https://www.pearson.com/us/privacy-statement.html</a>
TTCT/ITBS	<a href="https://www.ststesting.com/index.html">https://www.ststesting.com/index.html</a>	<a href="https://ststesting.com/privacySTS.html">https://ststesting.com/privacySTS.html</a>
Noredink.com	<a href="https://www.noredink.com/">https://www.noredink.com/</a>	<a href="https://www.noredink.com/privacy">https://www.noredink.com/privacy</a>
Khan Academy	<a href="https://www.khanacademy.org/">https://www.khanacademy.org/</a>	<a href="https://www.khanacademy.org/resources/parents--mentors--1#privacy--and--security">https://www.khanacademy.org/resources/parents--mentors--1#privacy--and--security</a>
Kodable	<a href="https://www.kodable.com/">https://www.kodable.com/</a>	<a href="https://www.kodable.com/privacy">https://www.kodable.com/privacy</a>
Quaver	<a href="https://www.quavermusic.com">https://www.quavermusic.com</a>	<a href="https://www.quavermusic.com/ParentTeacher/pdfs/PrivacyPolicy.pdf">https://www.quavermusic.com/ParentTeacher/pdfs/PrivacyPolicy.pdf</a>
Commonlit	<a href="https://www.commonlit.org">CommonLit.org</a>	<a href="https://www.commonlit.org/en/privacy.html">https://www.commonlit.org/en/privacy.html</a>
Peardeck	<a href="https://www.peardeck.com">https://www.peardeck.com</a>	<a href="https://www.peardeck.com/privacy/">https://www.peardeck.com/privacy/</a>
Essential Elements Interactive	<a href="https://www.essentialelementsinteractive.com">https://www.essentialelementsinteractive.com</a>	<a href="https://www.essentialelementsinteractive.com/EEI%20COPPA%20Privacy%20Policy%206-18.pdf">https://www.essentialelementsinteractive.com/EEI%20COPPA%20Privacy%20Policy%206-18.pdf</a>
Flipgrid	<a href="https://www.flipgrid.com">https://www.flipgrid.com</a>	<a href="https://legal.flipgrid.com/privacy.html">https://legal.flipgrid.com/privacy.html</a>
Classcraft	<a href="https://www.classcraft.com">https://www.classcraft.com</a>	<a href="https://www.classcraft.com/privacy-policy/">https://www.classcraft.com/privacy-policy/</a>

Дүүрэг зарим чухал хэрэгцээтэй сайтуудын тухай мэдээлэл болон хураангуйг хариуцдаг. Дараах холбоосруу ороход эцэг эхэд ээлтэй дүүргийн програмын жагсаалт руу орно: [програмын жагсаалт- 1: 1 Эцэг эх хувилбар - 19-20С](#)

Бүх ангиуд	зөвхөн анхан шатны	Анхан шатны / Завсрын	завсрын	завсрын дунд шатны	зөвхөн дунд сургууль	зөвхөн дунд сургууль
Google Apps Account (Mail, Drive, 2 new Google Doc apps)	ScootPad	RAZ Kids Learning A-Z Reading A-Z RAZ Kids ELL Edition Science A-Z Writing A-Z	MackinVia	Quizlet App and Website	Noredink.com	Animoto.com
Educreations		XtraMath	Axis 360	SmartMusic	<a href="http://ed.ted.com">http://ed.ted.com</a>	Learnzillion.com
Popplet		Epic		SRA Reading Labs	<a href="http://easybib.com">easybib.com</a>	Educanon.com
Brainpop				Thinglink	<a href="http://conjugemos.com">conjugemos.com</a>	Voicethread.com
Follett Brytewave -- Destiny Discover					<a href="http://wordplay.com">wordplay.com</a>	<a href="https://www.more.com/app">https://www.more.com/app</a>
Schoology					Biblionasium	<a href="http://easel.ly/">http://easel.ly/</a>
NewsELA					<a href="http://emaze.com">emaze.com</a>	Flashcard Elite
Freckle					Prodigy	
Class Dojo						reading-rewards.com
Seesaw						Zaption
Hour of Code <a href="http://code.org">code.org</a>						<a href="http://readtapestry.com">readtapestry.com</a>
NoodleTool						<a href="https://www.noodletools.co">https://www.noodletools.co</a>

						m/
Tinkercad						
edpuzzle						
IXL						
Bitsboard						
Khan Academy						
Kodable						
Spelling City						
Padlet						
Duolingo						

## 5.2 Анх суулгасан програм хангамж / Апп

Glenview 34-дүүргээс анх тараасан програм хангамж/Апп-ийг Дүүргийн iPad дээр ашиглах боломжтойгоор, байнга ашиглахад хялбар байдлаар хадгалсан байх ёстой. Зарим үед сургууль тодорхой хичээлд ашиглах програм хангамж / Апп-ийг нэмж болно. Дүүргийн iPad-уудыг үе үе шалгаж, сурагчид шаардлагатай апп-ыг хасаагүй эсвэл сургуулийн зөвшөөрөлгүй апп-ыг нэмж оруулсан эсэхийг шалгана.

## 5.3 Нэмэлт Програм хангамж

Сурагчид багш нарын эсвэл сургуулийн ажилтнуудын зөвшөөрснөөс бусад тохиолдолд Дүүргийн iPad-д нэмэлт програм хангамж суулгах, гэрийн компьютерт холбох зэргийг зөвшөөрөхгүй. Glenview 34-р Дүүрэг дүүргийн iPad дээр шаардлагатай Апп түгээх ажлыг хариуцна. Сурагчид дүүргийн iPad-ыг давхцуулан ажиллуулах, iTunes дансанд давхцуулах, эсвэл 34-р дүүргийн бус апп зөвшөөрөлгүйгээр дүүргийн iPad-д суулгахыг зөвшөөрөхгүй.

## 5.4 Програмыг дахин ачаалах журам

Хэрэв техникийн хүндрэл гарсан эсвэл 34-р дүүргийн бус хууль бус програм хангамж илрүүлбэл дүүргийн iPad-ыг нөхөн сэргээх болно. Дүүрэг дахин сэргээх, дахин хөрвүүлсний улмаас устгагдсан програм хангамж, баримт бичигт хариуцлага хүлээхгүй.

## 5.5 Програм хангамжийн шинэчлэлт

Баталгаажсан програм хангамж/апп-ын шинэчлэгдсэн хувилбарыг үе үе ашиглах боломжтой. Дүүрэг сурагч, ажилтнуудад төлөвлөсөн харилцаагаар дамжуулан дүүргийн бүх iPad-уудыг шинэчлэх боломжийг эдлэнэ.

## 5.6 Дүүргийн хяналт

Дүүргийн сурагчдын аюулгүй байдал, сайн сайхан байдал чухал ач холбогдолтой бөгөөд үүнд дүүргийн iPad ашиглах явцад сурагчдын нийгмийн дундахь сэтгэл хөдлөлийн зан төлөвийн байдал мөн хамаарна. Дүүрэг нь дүүргийн iPad дээрх сурагчдын вэб хайлт, текстэд суурилсан харилцаа холбоо, ажлын бүтээлийг хянах зорилгоор гуравдагч талын програм хангамжийг ашигладаг. Хэрэв сурагч дүүргийн iPad-г ашиглан өөрт аюултай, заналхийлсэн болон бусад сурагчдад (жишээ нь дээрэлхэх, амиа хорлох гэх мэт) үйлдэл эсвэл Дүүргийн дүүрэм зөрчсөн үйлдэл (жишээлбэл порнограф) гарсаныг хяналтын програм хангамжаар дамжуулан дүүргийн

томилогдсон ажилтанд сэрэмжлүүлэг очдог. Сэрэмжлүүлэг очсон тохиолдолд сургуулийн зохих ажилтанг оролцуулахаар мэдээлэл очно. ДҮҮРЭГ АЖЛЫН БУС ЦАГААР ИРСЭН СЭРЭМЖЛҮҮЛЭГТ ХЯНАЛТ ТАВИХ ҮҮРЭГГҮЙ БА СУРАГЧ БОЛОН ЭЦЭГ ЭХ АЖЛЫН БУС ЦАГААР ИРСЭН СЭРЭМЖЛҮҮЛЭГТ ХАРИУЦЛАГА ТООЦОХГҮЙ ХЭМЭЭН ҮЗЭЖ БОЛОХГҮЙ ЮМ. АЖЛЫН БУС ЦАГААР ИРСЭН СЭРЭМЖЛҮҮЛЭГТ ДАРААГИЙН АЖЛЫН ӨДРИЙГ ХҮРТЭЛ АРГА ХЭМЖЭЭ АВАГДАХГҮЙ. Тиймээс эцэг эх хүүхдийнхээ эрүүл мэнд, сайн сайхан, аюулгүй байдал, Дүүргийн iPad-ийн ашиглалтад хяналт тавих үүрэгтэй гэдгээ ухамсарлах ёстой.

## **6.0 ЗӨВШӨӨРӨГДСӨН ХЭРЭГЛЭЭ**

### **6.1Хариуцлагын тухай мэдэгдэл**

Дүүргийн iPad-г ашигласнаар сурагч Удирдах Зөвлөлийн бүх бодлого, дүрмийг дагаж мөрдөхийг хүлээн зөвшөөрч байгаа ба зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй үүнд Бодлого 6:235 (1.0 хэсгийг үзнэ үү)-Цахим сүлжээнд нэвтрэх, Бодлого 7:180 Дээрэлхэлт, Доромжлол, Бодлого 7:190 Оюутны сахилга бат зэрэг багтана. Glenview 34-р Дүүргийн технологи, сүлжээг ашиглах нь танд олгодсон давуу эрх бөгөөд эрх биш юм шүү. Glenview сургуулийн 34-р дүүргийн технологийн нөөцийг ашиглах давуу эрхийг шилжүүлэх боломжгүй юм. Энэ гарын авлага нь бүх хэрэглэгчид технологийн нөөцийг зохистой, үр ашигтай, ёс зүйтэй, хууль ёсны хүрээнд ашиглахтай холбоотой үүрэг хариуцлагын талаар мэдээлэх зорилготой. Хэрэв сурагч Удирдах Зөвлөлийн бодлого, журам, энэхүү гарын авлагын аливаа заалтыг зөрчсөн тохиолдолд дүүргийн iPad ашиглах эрхийг цуцалж, дүүргийн технологт нэвтрэх эрхийг татгалзаж, Glenview сургуулийн 34-р дүүргийн ёс зүйн дүрэм, Удирдах Зөвлөлийн бодлогын дагуу зохих сахилга батын арга хэмжээ ноогдуулна.

Glenview 34-р дүүргийн сүлжээнд холбогдсон компьютер болгон интернетийн сүлжээг ашиглах боломжтой. Сүлжээний админууд найдвартай үйлчилгээг хангахын тулд хүчин чармайлт гаргаж ажиллана. Гэсэн хэдий ч Дүүрэг үргэлж найдвартай, бүрэн ажиллагаатай байна гэдэгт баталгаа өгөхгүй юм.

Дүүргийн iPad-ийг ашиглан хийсэн харилцаа холбоо, мөн хадгалагдсан зүйлийн агуулгын нууцлалд баталгаа байхгүй болно. Дүүрэг дүүргийн iPad, түүний агуулгыг ямар ч үед, ямар ч шалтгаанаар шалгах эрхтэй.

Сурагч дүүргийн iPad болон дүүргийн сүлжээнд хэлсэн, хийсэн зүйлдээ хариуцлага хүлээнэ. Олон мянган хүмүүстэй холбоо тогтоох нь хурдан бөгөөд хялбар байдаг. Тиймээс хэрэглэгчтэй харилцахаасаа өмнө түр зогсоод, бодох, бусад хүмүүс болон тэдний санаа бодлыг хүндэтгэх нь чухал юм.

### **6.2Эцэг эх / асран хамгаалагчийн үүрэг хариуцлага**

Та телевиз, утас, кино, радио гэх мэт мэдээллийн хэрэгслийн эх үүсвэрийг сонгож ашигладагтай адил интернэт ашиглалтын талаар таны хүүхэд дагаж мөрдөх ёстой үнэт зүйлс, стандарт хэмжүүрийн талаар хүүхэдтэйгээ ярилцаарай. Дүүрэг дүүргийн бүх iPad-ад сургуулийн дотор болон гадна орчинд шүүлтүүртэй интернетээр хангана. Гэрийн интернетийн шүүлтүүр ажиллахгүй, санаандгүй байдлаар зохисгүй материалд нэвтрэх тохиолдолд дүүрэг хариуцлага хүлээхгүй. Мөн дүүрэг сургуулиас гадна орчинд сурагчын интернетийн хэрэглээнд хяналт тавих үүрэггүй. Эцэг эх / асран хамгаалагч хүүхдээ сургуулийн бус орчинд байхад хүүхдийнхээ iPad ашиглалт, түүний дотор интернетэд хяналт тавих үүрэгтэй гэдгээ хүлээн зөвшөөрөх. Хэрэв эцэг эх / асран хамгаалагч энэ хариуцлагыг биелүүлэхийг хүсэхгүй бол Сурагч, Эцэг Эхийн Дүүргийн iPad-ийн

хэрэглээний зөвшөөрлийн хуудас дээр тусгаж сурагч Дүүргийн iPad-ийг сургууль дээрээ үлдээх арга хэмжээг авна.

### **6.3 Сургуулийн үүрэг хариуцлага**

- Сурагчдад интернет, имэйлээр хангах. Зохисгүй материалыг манай дүүргийн шүүлтүүрийн системээр дамжуулан интернет, имэйлийг шүүх. Дүүрэг сургуулиас гадуур сурагчдын интернетэд хяналт тавих үүрэггүй. Дүүрэг нь хууль бус, порнограф, эсвэл насанд хүрээгүй хүүхэд компьютер ашиглах, хүүхдэд хор хөнөөлтэй материал ашиглахаас урьдчилан сэргийлэх зорилгоор шүүлтүүрийн програм хангамжийг сонгох, хэрэгжүүлэх, програмыг хаах, бусад технологийн хамгаалалтын арга хэмжээг авахад шударга, зохистой ажилласан гэж үзнэ. Гэсэн хэдий ч хэрэглэгч Сүлжээг ашигласнаар технологийн авах хэмжээ нь бүх хориотой материалд нэвтрэхээс урьдчилан сэргийлж чаддаггүйтэй адил хоритой бус материалд нэвтрэхэд хамгаалдаг гэдгийг мөн хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Дүүрэг хэрэгжүүлсэн технологийн хамгаалалтын арга хэмжээгээр олж авсан хандалт үгүйсгэлд хариуцлага хүлээхгүй.
- Сүлжээний мэдээлэл хадгалалтын багтаамжаар хангах. Glenview 34-р Дүүрэг дүүргийн iPad-дад хадгалагдсан, дамжуулсан мэдээллийг үзэх, хянах, хязгаарлах, технологийн нөөцийг зохисгүй ашиглаж буйг шалгах эрхтэй.
- Сурагчдад судалгаа хийхэд туслах зорилгоор ажилтнуудын удирдамжаар хангаж өгөх, Цахим сүлжээнд нэвтрэх бодлогод нийцэхэд сурагчдад хяналт тавихад туслах.

### **6.4 Сурагчын үүрэг хариуцлага**

- Хэрэв сурагч зохисгүй эсвэл доромжилсон үг хэллэг агуулсан имэйл болон бусад цахим мессежийг хүлээн авах эсвэл тухайн сэдэв нь эргэлзээтэй байдал төрүүлж байвал сурагч төхөөрөмжөө сургуулийн оффис дээр авчирна.

## **7.0 Бусад**

### **7.1 ДҮҮРГИЙН IPAD -ААС ТАТГАЛЗАХ ХОЛБОГДОХ НЭХЭМЖЛЭЛ**

Сурагч, Эцэг Эх Дүүргийн iPad-ыг ашиглах доорхи зөвшөөрөлд үсэг зурснаар та энэхүү Гарын Авлагад заасан бүх үүрэг хариуцлагыг уншиж, ойлгож, хүлээн зөвшөөрч байгаа гэдгээ хүлээн зөвшөөрч байна. Та дүүргийн iPad-ийг сайн ажиллагаатай түвшинд хүлээж авсантай адил сайн ажиллагаатай хэмжээнд буцааж өгөх ёстой гэдгээ хүлээн зөвшөөрч байна. ТА ЭНЭ ГЭРЭЭНД ГАРЫН ҮСЭГ ЗУРСНААР ТАНД (ТАНЫ ӨВЛӨГЧ, ЗАЛГАМЖЛАГЧ БОЛОН ХАРИУЦАГЧ) БАЙЖ БОЛОХ 34-Р ДҮҮРЭГ, БОЛОВСРОЛЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ТҮҮНИЙ ГИШҮҮД, АЖИЛТНУУД, ХОЛБОГДОХ АГЕНТУУДЫН ЭСРЭГ МЭДҮҮЛСЭН ЭНЭХҮҮ ГЭРЭЭ БОЛОН ДҮҮРГИЙН IPAD-ИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ТАЛААР ҮҮССЭН БҮХ НЭХЭМЖЛЭЛЭЭС ТАТГАЛЗАЖ БАЙНА.

### **7.2 ДҮҮРГИЙН IPAD-ИЙН НЭХЭМЖЛЭЛТЭЙ ХОЛБООТОЙ НӨХӨН ТӨЛБӨР**

ХУУЛИАР ЗӨВШӨӨРӨГДСӨН БҮРЭН ХЭМЖЭЭГЭЭР 34-Р ДҮҮРЭГ, БОЛОВСРОЛЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ТҮҮНИЙ ГИШҮҮД, АЖИЛТНУУД, ХОЛБОГДОХ АГЕНТУУДЫГ ЭНЭХҮҮ ГАРЫН АВЛАГА БОЛОН ДҮҮРГИЙН IPAD-ИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ТАЛААР ҮҮССЭН ЯМАР Ч ТӨРЛИЙН БҮХ НЭХЭМЖЛЭЛ, ХОХИРОЛ, АЛДАГДАЛ,

ШАЛТАГЛАЛ, ТҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ БУЮУ ҮҮССЭНТЭЙ ХОЛБООТОЙ ЗҮЙЛД  
НӨХӨН ТӨЛБӨР ОЛГОЖ, ХАМГААЛЖ, ХОХИРОЛГҮЙ БОЛГОХОО ЗӨВШӨӨРЧ  
БАЙНА.

Glenview сургуулийн 34-р Дүүрэг  
Сурагч Эцэг Эх Дүүргийн iPad хэрэглэх үүрэг

*Сурагчын үүрэг хариуцлага:*

Надад өгсөн Дүүргийн iPad-дад би сайн анхаарал тавих болно. Би Дүүргийн iPad-ыг хэзээ ч эзэнгүй орхихгүй.

Би Дүүргийн iPad-ыг бусад хүнд хэзээ ч зээлээр өгөхгүй. Миний iPad хаана байгааг би үргэлж мэдэж байх болно.

Би Дүүргийн iPad-ыг өдөр бүр цэнэглэж байна.

Би Дүүргийн iPad-аас хоол хүнс, уух зүйлсийг хол байлгах болно.

Би Дүүргийн iPad-ийн аль ч хэсгийг задлахгүй, эсвэл өөрөө ямар нэгэн засвар хийх гэж оролдохгүй.

Би Дүүргийн iPad-г зөвхөн тарааж өгсөн зориулалтын хавтас дотор авч явах болно.

Би Дүүргийн iPad-г 34-р дүүргийн шаардлагад нийцсэн, тохиромжтой, сургалтын чиглэлээр ашиглах болно.

Би Дүүргийн iPad-дээр чимэглэл (наалт, тэмдэглэгээ гэх мэт) наахгүй.

Би Glenview сургуулийн 34-р дүүргийн өмч болох аль ч iPad-ийн өмчийн тэмдэгийн наалт эсвэл бусад дүүргийн шошгыг баллахгүй.

Дүүргийн iPad нь нэмэлт мэдэгдэлгүйгээр ямар ч үед хяналт, шалгалтанд хамруулах бөгөөд Glenview сургуулийн 34-р дүүргийн өмч гэдгийг би ойлгож байна.

Би хүн нэг бүрд эзэмшүүлэх Дүүргийн iPad-ыг сургууль дээр байх болон сургуулиас гадуур байх үедээ Сурагч Эцэг Эхийн гарын авлагад тусгагдсан Бодлого, Дүрэм, Зааварчилгаа, Удирдах Зөвлөлийн Бодлого, дүрэм, журамд тусгагдсаны дагуу дагаж мөрдөнө.

Дүүргийн iPad-д гарсан галын аюул, хулгай, хорон сүйтгэл, алдагдал, бусад гэмтэл гарсан тохиолдолд би ангийн багшдаа даруй мэдэгдэх болно.

Үл тоомсорлох, урвуулан ашиглахтай холбоотой бүхий л хохирол, алдагдлыг би өөрөө хариуцна.

Би Дүүргийн iPad, хавтас, кабель, залгуур болон бусад дагалдах хэрэгслийг хэвийн ажиллагаатай нөхцөлд буцааж өгөхөө зөвшөөрч байна.

*Эцэг эхийн үүрэг хариуцлага:*

Миний хүүхэд Дүүргийн iPad-ыг гэртээ болон бусад газар ашиглах бусад газарт ашиглах явцад би хяналт тавих болно. Би хүүхдийнхээ гэртээ Интернет ашиглалтад бүрэн хяналт тавьж, хариуцна.

Би дүүргийн iPad-г засах гэж оролдохгүй ба цэвэр, хуурай даавуунаас өөр зүйлээр цэвэрлэхгүй.

Би дүүргийн iPad-тай холбоотой ямар нэгэн асуудлыг сургуульд мэдээлэх болно.

Дүүргийн iPad-г өдөр бүр сургууль дээр авчрахад би анхаарлаа хандуулна.

Хэрэв миний хүүхэд сургуульдаа iPad-гүй ирсэн тохиолдолд ангийн зарим үйл ажиллагаанд оролцохгүй болж, түүний дүнд нөлөөлж болзошгүйг би ойлгож байна.

Дүүрэг сурагчдын iPad-ын хэрэглээний програм хангамжид хязгаарлагдмал хяналт шалгалтыг хийдэг бөгөөд үүнтэй холбоотой хяналт, шалгалтад холбогдох анхааруулгыг зөвхөн ажлын цагаар шийдвэрлэх боломжтой гэдгийг би ойлгож байна.

Хичээлийн жилийн төгсгөлд iPad-ыг буцааж өгөхийг хүссэн тэр өдөр болон миний хүүхэд сургуулиас явсан тохиолдолд Дүүргийн iPad-ыг буцаан өгөхөө зөвшөөрч байна.

IPad-ийг хүн нэг бүрд эзэмшүүлэх Сурагч Эцэг Эхийн гарын авлага, Сурагч Эцэг Эхийн iPad хэрэглээний үүрэг хариуцлагад тусгагдсан заалтуудыг ойлгож хэрэв зөрчсөн тохиолдолд Удирдах Зөвлөлийн бодлого болон 34-р Дүүргийн Ёс зүйн дүрэмд тусгагдсаны дагуу хариуцлага хүлээх болно гэдгийг ойлгож байна.

Сурагчийн гарын үсэг

Огноо

Эцэг эхийн гарын үсэг

Огноо

Миний хүүхэд iPad-аа гэрлүүгээ авч явна.

Эцэг эхийн гарын үсэг

Огноо